

	<p>чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх</p>	<p>зорилгоор ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэх</p>	<p>1. 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх Төрийн албаны тухай хуулийг сурталчилах, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг</p> <p>2. Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын 1.3 дахь заалтыг хэрэгжүүлэх буюу Яамны зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийх, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллав.</p> <ul style="list-style-type: none"> - Ажлын байрны тодорхойлолтод шинжилгээ, судалгаа хийх, ажлын байрны хийдэл, давхардал, шаардлагыг тодорхой болгон шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 9 дүгээр сард багтаан ажлыг дуусгаж удирдлагад танилцуулав. - Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 05-өдрийн “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 370 дугаар тогтоолоор тус яамны бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотой чиг үүрэг нь өөрчлөгдсөн ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэн баталсан. - Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийн хүрээнд “Төрийн албан хаагчийн Албан тушаалын тодорхойлолт”-ын шинэ загварт нийцүүлэн боловсруулж, батлуулахад бэлэн болсон. 	
3	<p>4.1.1.7. Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод</p>	<p>4. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол мэдээлэл өнөөдрийн байдлаар гараагүй байна. Гомдол санал хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх талаар ХШҮДАГ-тай хамтран ажиллах УУХҮЯ-ны дэргэдэх Төрийн</p>	<p>ТЗУГ, ХШҮДАГ, ЭБАТ</p>

	хяналтын тогтолцоог бүрдүүлэх		албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны 19/01 дүгээр тогтоол гарсан.	
3	4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах	5. Албан хэрэг хөтлөлтийн ABLE цахим системийг ашиглан бусад Төрийн байгууллагуудтай холбогдох боломжийг бүрэн ашиглах	- Ажлын үр дүн, хариуцлагыг өндөржүүлэх, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, төрийн болон бусад байгууллагуудтай шууд харицах боломжтой албан хэрэг хөтлөлтийн ABLE цахим https://intranet.gov.mn/ системд шилжин Засгийн газрын албан хэрэг хөтлөлтийн программыг үйл ажиллагаандаа хэрэглэн ажиллаж байна. - ABLE программыг бүрэн ашиглах, ажлын үр дүнг тооцох ажлыг зохион байгуулж байна. Тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн ажлын төлөвлөгөөнд давхар тусган, жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн байна.	ТЗУГ
4	4.1.1.10. нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	6. АТГ-ын Олон нийтийн төвд зохион байгуулагдах бүх сургалтад албан хаагчдыг жигд оролцуулах	АТГ-ын Олон нийтийн төвд 2018 оны 1-р улиралд зохион байгуулсан сургалтад 39 албан хаагч, 2-р улиралд 18 албан хаагч оролцсон.	ТЗУГ, ЭБАТ
		7. УУХҮЯ-ны албан хаагчдын 2018 оны сургалтын төлөвлөгөөнд Авилгын эсрэг болон төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг төлөвшүүлэх бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалтуудыг тусган батлуулах, төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулах	УУХҮЯ-ны албан хаагчдын 2018 оны сургалтын төлөвлөгөөнд: -Төрийн захиргааны удирдлага, хандлага, төлөвшил, төрийн албан хаагчийн ёс зүй - Монгол төрийн түшмэл уламжлал, хөгжил - Хяналт шинжилгээ үнэлгээний шинэ арга механизм зэрэг сургалтууд төлөвлөгдсөн бөгөөд 3-р улиралд багтаан зохион байгуулж, яамны нийт албан хаагчид оролцов.	ТЗУГ, ЭБАТ
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
5	4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	8. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын төлөвлөгөөний гаргаж, төлөвлөсөн ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхийн тулд дотоод сүлжээ, түүнд ашиглагдаж буй программ хангамжийг шинэчлэх ажлын төлөвлөгөө төсвийг боловсруулан батлуулж, 10-р сард яамны засварын ажлын хамт гүйцэтгэж дуусгалаа.	ТЗУГ

		9. Яамны цахим сүлжээнд авилгын эсрэг төлөвлөгөөг байршуулах, санал, сэтгэгдэл хүлээж авах боломжийг бүрдүүлэх	“Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан яамны www.mmhi.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Иргэд олон нийтээс санал сэтгэгдэл хүлээж авах бүх боломж хангагдсан.	ТЗУГ, ХШУДАГ
6	4.1.2.4. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	10. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	- Хяналт шалгалт хийх объектийн эрсдлийг урьдчилан тодорхойлж, жил бүрийн эхэнд дотоод аудитын төлөвлөгөөг сайдаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. УУХҮСайдын 2018.02.23-ний өдрийн А/36 дугаар тушаалаар 2018 оны дотоод аудитын төлөвлөгөөг батлуулсан. Хяналт шалгалтыг хуулийн хэрэгжилт, төсөв санхүүгийн гэсэн 2 чиглэлээр хийж байна. Төлөвлөгөөний дагуу “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-д дотоод аудит хийн удирдлагад танилцуулсан. - Яамны хэмжээнд мэргэжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд аж ахуйн нэгж, компаниудад хийгддэг жилийн төлөвлөгөөт үзлэг, үйл ажиллагаатай танилцах, төр хувийн хэдшлийн ажлын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр хяналт шалгалтын ажлыг явуулж байна. Хяналт шалгалтын ажлын 70 хувийг ажлын зохион байгуулалт, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэж байна.	ТЗУГ, ХШУДАГ
Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
7	4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	11. Яамны санхүүгийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх	- Шилэн дансны тухай хуулийн дагуу УУХҮ-ийн Сайд, УУХҮЯ-ны санхүүгийн мэдээллийг цаг тухай бүр нь shilendans.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна. Сайтад байршуулах ёстой мэдээллийг 100% цаг тухай бүр нь байршуулсан. 2018 онд УУХҮЯ Засгийн газрын тусгай сангаас ямар нэгэн санхүүжилт аваагүй.	ТЗУГ, СХ

Зургаа. Авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр

8	4.1.6.5. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах	<p>12. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах талаар эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Боловсруулах салбарын ил тод байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор салбарт үйл ажиллагаа эрхэлдэг бүх аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж тэдгээрийг бүртгэлжүүлэн нэгдсэн мэдээллийн сантай болов. - "Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. - "Хайлуур жоншны үйлдвэрлэл, экспортыг дэмжих зорилтот хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж, нөлөөллийн шинжилгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэн, яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. - "Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын төслийг боловсруулан аж ахуйн нэгж, иргэдээс санал авч байна. - "Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм", Хүнд үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалт, маягыг батлуулах тушаалын төсөл боловсруулан, аж ахуйн нэгж, иргэдээс санал авч байна. - УУХҮ-ийн сайд, удирдлагууд сар бүрийн сүүлийн 7 хоногт УУХҮЯ дээр "Ил тод хариуцлагатай уул уурхай" хэвлэлийн бага хурлыг зохион байгуулдаг бөгөөд салбарын асуудлаар ил тод мэдээлэл өгдөг. 	Бүх газар, хэлтэс
		13. Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Орд ашиглах гэрээ, Орон нутгийн хамтын	2018 оны байдлаар хөрөнгө оруулалтын болон орд ашиглах гэрээ хийгдээгүй болно.	ТЗУГ

		<p>ажиллагааны гэрээнүүдийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ил тод болгох ажлыг зохион байгуулах</p>	<p>Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/06 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Өмнө нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага, Нээлттэй нийгэм форум болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 3 тал санамж бичгийг байгуулсан байдаг бөгөөд энэхүү санамж бичгийн хүрээнд дээрх ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг байгуулагдаад эрдэс баялгийн салбарын 11 төрлийн гэрээг цуглуулах үүрэгтэй байснаас 2018 оны жилийн эцсийн байдлаар 11 төрлийн 434 гэрээг холбогдох газруудаас татан авах ажил бүрэн дуусч /100%/, тодорхой хэсэг буюу 248 гэрээг /58%/ мэдээллийн цахим санд байршуулсан. 2019 оны эхний улиралд үлдсэн гэрээг цахим санд байршуулж дуусна. Цаашид ажлын хэсгийг шинэчлэн байгуулж эрлийн гэрээ болон бичил уурхай эрхлэгч нартай байгуулсан гэрээнүүдийг цахим санд байршуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.</p>	
		<p>14. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлэх</p>	<p>- Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсөвт байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, төсвийг тогтмол суулган баталж байгаа ба гэрээлэгчид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмын дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайланг БОАЖЯ-аар батлуулан ажиллаж байна. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмыг УУХҮ-ийн сайд болон БОАЖ-ийн сайд нарын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/50, А/31 тоот хамтарсан тушаалаар батлуулсан ба Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2018</p>	<p>ТЗУГ, ХҮГТБЗГ, ХХ</p>

			оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 3870 дугаарт бүртгүүлсэн. Тус журмын хэрэгжилтийг хангуулан, холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллах тухай 03/655 тоот албан бичгийг 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдөр АМГТГ-т явуулсан.	
		15. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулсан.	ХҮГТБЗГ, АМГТГ
Арав. Шудрага ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авилгын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
9	4.1.10.1. авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	16. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт сурталчилгааны ажлын хүрээнд АТГ-аас шинэчлэн хэвлүүлсэн “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг олшруулан нийт албан хаагчид болон иргэдэд 50 ширхэгийг тарааж, судлах, сурталчлах ажлыг зохион байгуулав.	ТЗУГ, бүх газар хэлтэс
		17. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлан, мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх	Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд давхар ажил эрхлэлт, хамаарал бүхий этгээдийн судалгаа, ХАСУМ хянуулсан судалгаа, Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэх бүртгэл зэрэг судалгаа, мэдээллийн санг бий болгосон. - Тайлан, мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэв.	ТЗУГ, ЭБАТ
Яамны эрхлэх ажлын хүрээнд				
10	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	18. Хуулиар болон бусад холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрээр зөвшөөрөгдсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулах	Хуулиар болон бусад холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрээр зөвшөөрөгдсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг албан хаагчдад танилцуулав.	ТЗУГ, ЭБАТ

	19. Давхар ажил эрхлэлтийн судалгааг гаргаж, АТГ-д хүргүүлэх	Давхар ажил эрхэлж байгаа ажилтны судалгааг шинэчилж, АТГ-д хүргүүлсэн.	ТЗУГ, ЭБАТ
--	--	---	---------------

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

М.БАЯРАА

СТРАТЕГИ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Э.БАТБОЛД

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ДАРГА

Б.МӨНХТӨР

ХҮНД ҮЙЛДВЭР, ГАЗРЫН ТОСНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА

Б.АНХБАЯР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Г.ГАНХҮҮ

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТЗУГ-ЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Ш.УРАНЧИМЭГ